



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/533

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Аялал жуулчлалын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтууд, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны хоёрдугаар хуралдааны 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа уялдаа холбоог сайжруулах, хүний нөөцийг чадавхижуулах сургалт семинарыг зохион байгуулах, иргэд олон нийтэд аялал жуулчлалыг сурталчлан таниулах зорилготой зохион байгуулсан "Дэлхийн аялал жуулчлалын өдөр" арга хэмжээний зардалд 5,800,000 (таван сая найман зуун мянга) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал болон аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231012474

**“ДЭЛХИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨДӨР”-ИЙН ХҮРЭЭНД
ЗОХИОН БАЙГУУЛСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ**

№	Зардлын нэр, төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ	Эх үүсвэр
1	Мэргэжлийн байгууллагын сургалтын төлбөр	2 өдөр * 3 багш		1,800,000	АЗДҮАХ-ийн зардал
2	Өдрийн хоол	60 хүн	15,000	900,000	АЗДҮАХ-ийн зардал
3	Цайны завсарлага	60 хүн	5,000	300,000	АЗДҮАХ-ийн зардал
4	Оройн хоол	60 хүн	30,000	1,800,000	АЗДНСан
5	Үйл ажиллагааны халдвар хамгааллын зардал /Амны хаалт, ариутгалын бодис, бээлий г.м/	2 өдөр		100,000	АЗДҮАХ-ийн зардал
6	Шагнал урамшуулал			350,000	АЗДҮАХ-ийн зардал
7	Анонс	3*5 м	15,000	225,000	АЗДҮАХ-ийн зардал
8	Хэвлэлийн зардал /Өргөмжлөл, талархал/	5 ш	15,000	75,000	АЗДҮАХ-ийн зардал
9	Бусад бэлтгэл хангах /урлагийн номер/			250,000	АЗДҮАХ-ийн зардал
	НИЙТ			5,800,000	